

Төрөлхийн үхэл биднийг гэм нүгэл хийхэд хүргэдэг



Хүн төрөлхтөнд байсаар ирсэн хамгийн том бэрхшээл бол үхэл. Хүн бүр хэзээ нэгэн цагт үхэлтэй зайлшгүй тулгарна. “Үхэл ноёрхдог” болсон учраас тэр (Ром 5:17). Тэгвэл үхэл яагаад хүний амьдралыг ноёрхдог болсон бэ?

Энэ асуудал бид бүхний өвөг эцэг болох анхны хүн Адамын хийсэн буруугаас үүдэлтэй. Адамд Бүтээгч Эзэн, “Сайн муу мэдлэгийн модны жимснээс бүү ид. Чи түүнээс идвэл тэр дороо гарцаагүй үхнэ” гэж анхааруулжээ (Эхлэл 2:17, СМО). Энэ ишлэлийг еврей хэлнээс бүр нарийн орчуулбал Бүтээгч Эзэн: “чи түүнээс идсэн мөчөөс эхлэн үхэх гэж үхдэг байх болно” гэжээ.



Адам Бүтээгч Эзэний анхааруулгыг тоогоогүйн улмаас алдаж буруутсан. Ингээд хүн төрөлхтөний үйлдсэн анхны гэм нүгэл хийгджээ.

“Нүгэл” гэдэг нь Библийн дагуу энгийн алдаанаас эхлээд, эрх мэдэлт нэгний үгийг зөрчих, бусдыг хохироох, сэтгэлийг нь гомдоох хүртэлх янз бүрийн зөв бус үйлсийг багтаадаг. Буруу хандлага, буруу санаа сэдэл, мөн хийх ёстой сайн үйлсийг хийхгүй байх хүртэл гэм нүгэл мөн (Иаков 4:17).

Улмаар, “итгэлээр биш алив бүхэн нь нүгэл юм” гэсэн үг бий (Ром 14:23).

Анх нүгэл үйлдсэн тэр өдрөө Адам яалт ч үгүй үхлийн ял авчээ. Амьдрах хүчээр дутагдаж эхэлсэн Адам шууд амьсгаа хураагаагүй, харин мөнх бусаа үзүүлэх үйл явцад оров. Доройтон доройтсоор байж эцэст нь 930 настайдаа нас эцэслэв (Эхлэл 5:5).

Энэ явдлын талаар Паул хожим бичихдээ: “Нүгэл нь ганц хүнээр ертөнцөд орсны адил үхэл нь нүглээр дамжуулан орж ирэв...” (Ром 5:12).





Энэ бүхнээс харахад гэм нүгэл ба үхэл хоёр хоорондоо нягт холбоотой.

Хүн бүр Адамд оноосон ялын дор оржээ

Паул үргэлжлүүлэхдээ: “Энэ замаар үхэл бүх хүнд дамжин ирсний дээр бүгд нүгэл үйлдсэн” гэж бичив (Ром 5:12, миний орчуулга). Энэ өгүүлбэрийг эсрэгээр нь орчуулдаг нь түгээмэл. Үүнд: “Бүгд нүгэл үйлдсэн тул бүх хүнд үхэл иржээ” (АБ2019). Энэ нь теологичдыг “төрөлхийн нүгэл” гэдэг онол гаргахад хүргэсэн.

Тус онолын дагуу хүн өвөг дээдсээсээ гэмт чанарыг өвлөж авдаг бөгөөд өөрийн хийдэг гэмийнхээ улмаас нас бардаг.

ҮХЭЛ =====> НҮГЭЛ

ҮХЭЛ <===== НҮГЭЛ

Гэтэл дээрх ишлэлд “тул” гэж орчуулсан жижигхэн үг [грек: ἐπί, эпи] “дээр” эсвэл “-д” (“үүнд”) гэсэн утгатай учраас зөв орчуулга нь яг эсрэгээр нь байж таарна. Үүнд:

“Үхэл нь нүглээр дамжуулан орж ирэв. Ингээд үхэл бүх хүнд дамжин ирсэн бөгөөд үүнд [=энэ байдлаас болж, үхдэг болсон учраас] бүгд гэм хийсэн”. Эсвэл: “Энэ замаар үхэл бүх хүнд дамжин ирсний дээр бүгд нүгэл үйлдсэн.”



Адамаас бид гэм нүглийг өвлөж аваагүй, харин үхлийг буюу амийн хүчээр дутмаг байхыг өвлөж авсан гэсэн үг. Хүн бүр нэг ёсондоо “төрөлхийн үхэлтэй”. Нүгэл генээр дамжин хэрхэн удамшилж болохыг ойлгоход бэрх. Харин амийн хүчний дутагдал удамшлийн өвчин мэт дамждаг гэхэд ойлгоход амар. Энэ утгаар хүний “зүрх бол бүх зүйлээс илүү хуурамч бөгөөд эдгэршгүй өвчтэй” юм (Иеремиа 17:9).

Энэ ишлэлд “зүрх” нь цээжинд цохилох эрхтэнг биш, сэтгэлийн төв болох бодол санааг хэлнэ. Бид бүгд амийн хүчээр дутагдах “эдгэршгүй өвчтэй”. Тийм



учраас ямар ч гэм буруу хийж амжаагүй, хэвлийд буй хүүхэд хүртэл үхэх боломжтой. Адамаас гаралтай хүн бүр гэм нүгэл хийсэн ч, хийгээгүй ч ертөнцийн жам ёсоор нас барна. Адамыг өнөө зөрчил үйлдсэнээс хойш “үхэл ноёрхдог” болсон учраас тэр (Ром 5:17). Үхэл амьдралын бүх эмх цэгцийг үгүй болгож, гайхалтай зохицсон бүхнийг сүйтгэдэг. Амийн хүч дутснаас болж амьдралын эмх замбараа алдагдахад янз бүрийн алдаа дутагдал, гэм буруу орж ирэх нь зайлшгүй билээ. Үхлийн тэр завхруулагч нөлөөнөөс хэн ч зайлсхийх аргагүй. Энэ аргагүй байдлыг Паул мөн “ялзралын боолчлол” гэж нэрлэсэн (Ром 8:21).



Үхлийн хатгуур: нүгэл

Үхлийн тэр нөлөөг Паул хор бүхий “хатгуур” мэтээр дүрсэлсэн. Үүнд: “Үхлийн хатгуур нь нүгэл” (1 Коринт 15:56). Илчлэл 9:10-с харахад хилэнцэт хорхойд хортой тийм хатгуур бий. Үхэл хор дүүрэн хатгууртай мангас шиг хүнийг нэг ёсондоо гэм нүглийн хороор хатгасан. Хэрэв үхлийн үйл явц биднийг гэм нүгэл хийхэд хүргэдэггүй байсан бол, амьдрал хамаагүй гай багатай байх байсан. Үхэж явах нь дангаараа өвдөхгүй, харин хатгуур нь болох гэм нүгэл маш их өвчин зовлон, энэлэл шаналал бий болгодог билээ.

Даан ч Адамын дуулгаваргүй байдлаас болж бид бүгд өөрийн эрхгүй “нүгэлтэн болгогдсон”

(Ром 5:12+19; Ром 3:23).

Өөрөөр хэлбэл, хүн бүр яалт ч үгүй алдаж буруутдаг “нүглийн боол” болж төрдөг (Иохан 8:34; Ром 6:20).

Иймд “бүгд нүгэл үйлдсэн” (Ром 3:23).

“Нүгэл нь үхлээр [грек: үхэл дотор = үхэж буй хүмүүсийн дотор] ноёрхдог” болсон бөгөөд нүгэл хүнийг захирдаг (Ром 5:21).





Гэм хийхээс татгалзах хүч чадал хэнд ч байхгүй. Хүн нүгэлтэн болох эсэх тал дээр өөрөө шийдэх эрх ч байхгүй.

Паул өөрийн туршлагаасаа хуваалцахдаа, “би хийх хүсэлтэй зүйлээ хийдэггүй, харин үзэн яддаг зүйлээ хийж байна... Харин эдүгээ цаашид би биш, харин миний дотор оршин байгч нүгэл нь үүнийг үйлддэг юм... Би өөрийн хүсдэг сайныг хийдэггүй, харин хүсдэггүй бузар муугаа хэрэгжүүлдэг. Хэрэв би өөрийн хүсдэггүй зүйлээ хийж байгаа бол цаашид би биш, харин миний дотор оршин байгч нүгэл нь үүнийг үйлддэг” гэж бичсэн (Ром 7:15-20).



Үүнчлэн үхлийн хороор “эдгэршгүй өвчтэй” болсон хүн төрөлхтөний гишүүн бүр жам ёс заасны эсрэг, төрөлхийн мөс чанарынхаа эсрэг гаж буруу үйлс хийхэд хүрдэг. Өвчилсөн “зүрхнээс хорон муу бодол, аллага, завхайрал, садар самуун, хулгай, худал гэрчлэл, гүтгэлэг зэрэг нь гардаг” юм (Матай 15:19).



Хүний төрөлх чанар дорой ч гэсэн зөвийг эрэлхийлсэн хэвээр

Зарим теологичид “төрөлхийн гэмт чанар”-ын тухай ярихдаа хүн тэр чигтээ завхарсан гэж заадаг. Сайн юм юу ч үлдээгүй, тэр чигтээ тамд орвол зохих ёрын амьтан болсон гэж заана. Гэтэл энэ сургаал Библийн дагуу биш. Хүний төрөлх чанар нь муудаагүй, зөн билэг нь буруу зүйлийн эсрэг байдаг хэвээр гэдгийг бид амьдралаас ч мэднэ. Мөс чанар нь Бүтээгч Эзэний хүслийн дагуу чиглэсэн байдаг хэвээр учраас жам ёсоор явдаг хүн зөв юм хийдэг. Христэд итгэдэггүй боловч сайн хүмүүс олон бий.

Паул энэ талаар бичихдээ: “Харь үндэстнүүд [Мосегийн] Хуульгүй боловч төрөлх байдлаараа Хуулийн зүйлсийг үйлдвэл [=шаардлагыг нь гүйцэтгэвэл], Хуульгүй боловч тэдгээр нь өөрсдөд нь хууль болдог. Хуулийн шаарддаг үйлс нь тэдний зүрх сэтгэлд бичигдсэнийг тэд харуулдаг. Тэдний мөс чанар ч хамт гэрчилж, тэдний бодол санаа ч нэг нэгнээ буруутгадаг, эсвэл өмгөөлдөг” (Ром 2:14-15). Хүний завхраагүй төрөлх чанарын хамгийн сайн жишээний нэг бол монголчуудын алдаршуулан дуулдаг эх хүний хайр билээ.



Гэвч “удамшлын үхэл” бид бүхний дотор ажлаа хийдэг учраас бид хийхээр хүссэн олон сайн зүйл хийж чаддаггүй, хүчрэхгүй. Бидний амийн хүч хангалтгүй. Төгс хүн байхгүй, төгс ээж ч байдаггүй. “Сүнс хүсэж байна, харин махбод [үхлээс болж] дорой” учраас тэр (Матай 26:41; Ром 7:18б). Хүн доройтолд автсан учраас гэм нүгэл хийдэг.



Гэм нүглийн оноодог хувь бол үхэл

“Нүглийн хөлс бол үхэл” гэсэн алдартай ч алдаатай орчуулсан ишлэл бий (Ром 6:23). Энэ ишлэлээс ч болоод хүн гэм хийдэг учраас л нас бардаг гэсэн ойлголт гарах нь түгээмэл. Гэтэл тийм биш. “Үхэлд хүргэх нүгэл гэж бий... Үхэлд хүргэхгүй нүгэл гэж бий” (1 Иоган 5:16-17). Адамаас Мосе хүртэлх хугацаанд хүний зөрчиж болох Бүтээгч Эзэний тушаал өгөгдөөгүй тул гэмийг тооцдоггүй байсан. Тэгсэн ч гэсэн үхэл тэр үед ялгаагүй ноёрхдог байв (Ром 5:12-14).

Бүтээгч Эзэн өнөөдөр итгэгч хүний бүх гэмийг арчиж хаясан ч гэсэн итгэгч хүмүүс бусдын адил нас бардаг хэвээр. Хүн өөрийнхөө үйлдсэн гэмийн улмаас биш, харин Адамд оноосон үхэх ялын үр дүнд нас бардаг.



Үхлийн хатгуур гэм болохоос, гэмийн хатгуур үхэл биш ээ! Их Эзэний үгийг ингэж эргүүлэн гуйвууж болохгүй.

“Нүглийн хөлс бол үхэл” гэсэн орчуулгыг авч үзэхээр: Хөлс уг нь хийсэн ажлын хэмжээгээр өгөгддөг. Гэтэл нас барсан нялх хүүхэд Гитлерээс ч ялгаагүй үхэлд автсан. Сайн муу, Есүст итгэдэг итгэдэггүй бүх хүнд адилхан ирдэг үхэл хэрхэн хийсэн үйлсийнх нь үр дүн байж болох вэ? Хүний нас барах нь хийсэн гэмээс нь шалтгаалахгүй нь дахиад харагдаж байна.

Хүн “нүглийн боол” юм бол нүгэл “боолын эзэн” болж таарна. Гэтэл боолийн эзэн хэзээ ч боолдоо “хөлс” өгч цалинжуулдаггүй. “Хөлс” гэж орчуулсан грек үгийг нягтлан үзвэл, “цэрэг зэрэгт оногддог идэж уухын хувь, хүртээмж, ноогдол” гэсэн утгатай үг. Боол үнэхээр эзнээсээ амь залгуулах идэш уушны хувийг л авдаг.

Тэгвэл боолын эзэн болох “нүглийн оноодог хувь бол үхэл” гэж Ром 6:23-г орчуулж болно. Үхэл бол өдөр бүрийн идэж уухын хувь маань. Энэ хувьд Адамд оноогдсон үхэх үйл явцын зовлон багтдаг. Үхлийн явц нь амьдралыг ер нь хэцүү болгосон. Үхлийн явцын улмаас бид алддаг, ядардаг, өвддөг, өтөлдөг учраас ажил хийх нь түвэгтэй, хүнд хүчир болсон юм.



Дээр нь бидний үйлдсэн гэм “тарьснаа хураадаг” жамын дагуу амьдралд маань бодит үр дагаврыг дагуулна. Үүгээр ч зогсохгүй, бид өөрсдөө гэм хийсэн ч, хүний хийсэн нүглийн бай болсон ч,



дотроо буруутгал, эргэлзээ, санаа зоволт, уур хилэн, ичгүүр гутамшиг, айдас жихүүдэс, гуниг дарамт, гутрал зэргийг мэдрэн сэтгэлийн харанхуйд живэхэд хүргэдэг. Ийм хэцүү сэтгэлтэй явах нь амьдаараа үхсэн мэт байхыг олон хүн гэрчилж чадна.

Энэ бүхнээс харахад хүн төрөлхтөний үндсэн асуудал бол үхэл ба үхлээс үүдэх гэм хоёр.

Хүн үхлийг анхны өвөг дээдсээсээ өвлөсөн учраас өөрийн эрхгүй “нүгэлтэн болгогдсон” (Ром 5:19).


Энэ хоёр асуудлыг хүн дийлэх ямар ч аргагүй. Зөвхөн Бүтээгч Эзэн л эдгээр асуудлыг тайлж чадна.

Тиймээс үнэхээр гэм ба үхлийн шийдэх асуудлыг Өөрийн гартаа авсан.



Чухам үүнд Есүсийн тухай
Сайн мэдээ оршино.
Тухайлбал:

**“Христ бидний нүглийн
төлөө үхсэн бөгөөд
оршуулагдан, Бичвэрийн
дагуу гурав дахь
өдөртөө амилуулагдсан...”**
(1 Коринт 15:3-4). □



*Христийн үхэл хэрхэн хүн төрөлхтөний асуудлыг
шийдэн, шинэ эхлэл тавьсаныг дараагийн
нийтлэл дээр авч үзэх болно. Дээр нь гэм ба үхэл
Бүтээгч Эзэний төлөвлөгөөнд саад болоогүй,
харин ч чухал үүрэгтэй болохыг авч үзнэ.*

Хэрэглэсэн эх сурвалж

---Ариун Библи (2004; 2013; 2019). Улаанбаатар: Ариун Бичээс
Нийгэмлэг. Энэ судалгаанд АБ гэж товчилсон.

---Стандарт Монгол Орчуулгын апп (2023). Энэ судалгаанд СМО гэж
товчилсон.

---Strong, J. (1890). Strong's exhaustive concordance of the Bible (with
Greek and Hebrew Lexicons). www.blueletterbible.org